



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 666

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.2, 6.2.3, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төв-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 12 нэрийн, 173,311,901.17 (нэг зуун далан гурван сая гурван зуун арван нэгэн мянга есөн зуун нэг төгрөг арван долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. “Төв-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Н.Бат-Эрдэнэ, гүйцэтгэх захирал Д.Болдбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, хоёрдогч түүхий эд болгон худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2020 оны 12
дугаар сарын 08-ний өдрийн 606 дугаар
тогтоолын хавсралт

**"Төв-АЗЗА" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах
хөрөнгийн жагсаалт**

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Колонк штс	1999.01.01	1	24,890,556.00	24,890,556.00
2	Лабартори тоног төхөөрөмж	2000.01.01	1	110,947,860.00	110,947,860.00
3	Дайрга тараагч 40	2005.05.01	1	14,609,450.00	14,609,450.00
4	Асфальт зүсэгч хөрөө 15	2009.09.01	1	924,513.00	924,513.00
5	Бетон зуурагч	1997.04.01	1	3,093,333.00	3,093,333.00
6	Бетон зуурагч.	2009.06.01	2	5,226,390.91	10,452,781.82
7	Нягтруулагч 60	2009.09.01	1	3,392,340.00	3,392,340.00
8	Гар багаж	2000.05.01	1	4,695,600.00	4,695,600.00
9	Гацуур	1999.01.01	1	3,608.84	3,608.84
10	Шөнийн гэрэлтүүлэг	1999.01.01	1	6,658.51	6,658.51
11	Пүү 100кг	2006.09.01	1	126,500.00	126,500.00
12	Пүү 300кг	2006.09.01	1	168,700.00	168,700.00
			13		173,311,901.17
	Нийт дүн		(арван гурав)		(нэг зуун далан гурван сая гурван зуун арван нэгэн мянга есөн зуун нэг төгрөг арван долоон мөнгө)